

ХОРИХ БАЙГУУЛЛАГААС СУЛЛАГДСАН ИРГЭНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

THE ROLE OF LAW ENFORCEMENT AGENCIES AND PUBLIC SERVICE IN SOCIALIZATION OF INDIVIDUALS RELEASED FROM PRISON



О.ПҮРЭВСҮРЭН

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, нийгмийн ажлын магистр,
ахмад

PUREVSUREN O.

Institute execution of the judgment of the Court of Law Enforcement
University Senior Lecturer in the of Social Work, Master of Social Work and
captain

Товч агуулга: Хорих байгууллагаас суллагдах дөхсөн буюу суллагдсан иргэнд үзүүлж ирсэн нийгэмшүүлэх үйлчилгээг уламжлал, гадаадын зарим орны туршлагатай харьцуусан болно. Хууль сахиулах байгууллага болон төрийн үйлчилгээний байгууллагуудын үүрэг, оролцоо эрх зүйн орчинд нь дүгнэлт анализ хийж, цаашид суллагдсан иргэнд үзүүлэх нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг боловсронгуй болгох, оролцогч субъектуудын үүрэг оролцоо, хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй тайлбарлан дүгнэлт саналаа гаргасан болно.

Abstract: It compares socializing service for citizens, who have been released or are about to be released from prison, with traditions and some experiences of foreign countries. It analyzes role, participation and legal environment of law enforcement agencies and public service bodies, and gives suggestions, conclusions, explanations and proposals on further development of professional service of social work for citizens released from prison, and role, participation and cooperation of involving subjects.

Түлхүүр үгс: Ялтан, хорих ангиас суллагдсан иргэн, нийгэмшүүлэх үйлчилгээ, хууль сахиулах байгууллага, захиргааны хяналт, нийгмийн тусламж, дэмжлэг

Key words: Convicted person, citizen released from prison, law enforcement agencies, administrative supervision, social support.

1.1. Хорих байгууллагаас суллагдсан иргэнд үзүүлж ирсэн нийгмийн хяналт нийгэмшүүлэх үйлчилгээ, уламжлалт хандлага, гадаадын зарим орны туршлага

Манай улсад хорих ял эдэлж байгаа ялтан, цагдан хоригдогчдын сүүлийн 10 жилийн статистик тоо баримтаас үзвэл хорих байгууллагаас жилд 500-600 гаруй ялтан суллагдаж, тэдгээрийн 40-45 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж байна¹ гэсэн тоо баримт байгаа юм. Үүнээс үзэхэд хорих байгууллагаас суллагдсан иргэн давтан гэмт хэрэг үйлдэх явдал эрс нэмэгдэж байгаа нь тэдэнд тавих нийгмийн болон захиргааны хяналт сул, нийгэмшүүлэх ажил төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Хорих байгууллагад хорих ял эдлэгсдийн тоо жилээс жилд өгсөн нэмэгдэж улс орны эдийн засагт багагүй ачаалал, хүндрэлийг бий болгож байна. 2015 оны 4 сарын байдлаар нэг ялтанд оногдож байгаа зардал нэг өдөрт 10648 төгрөг, сард 319440 төгрөг байна. (Үүнийг 6000 хоригдлын тоог үзүүлэлтэнд харьцуулахад

¹ ШШГБ-н төв орон нутгийн удирдах ажилтны 2015 оны сургалт зөвлөгөөнд ШШГЕГ-н Тогтоол гүйцэтгэх газрын даргын тавьсан илтгэлээс.

сард 1.916.640.000 төгрөгний зардал гарч байна). Өнөөдрийн байдлаар төрийн үйлчилгээний албаны ажилтан сард дунджаар 350.000-400.000 төгрөгний цалин авч байгаа гэж бодвол төрийн үйлчилгээний ажилтны бүтэн сарын турш улсынхаа төлөө, амьдралынхаа төлөө зүтгэж олдог мөнгийг гэмт хэрэг үйлдсэн нэг ялтны хорих ял эдлүүлэх ажиллагаанд зарцуулж байна гэж ойлгож болох юм.

Иймд хорих байгууллагаас суллагдаж байгаа иргэдийг нийгэмшүүлэх, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тухайн иргэнийг нийгэмшүүлэхэд оролцдог, Хууль сахиулах байгууллага болон төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоо, явуулж буй үйл ажиллагааг нэгэн зорилго чиглэлтэй уялдаа холбоотой зохион байгуулах нь бидний өмнө тулгамдаж байгаа асуудал болж байна.

Хорих ял эдлэгсэд нь давтан гэмт хэрэг үйлдэж хувь хүн, албан байгууллага, нийгэмд хор хохирол учруулаад зогсохгүй, манай улсын эдийн засагт багагүй хэмжээний дарамт үүсгэдэг нь дээрх тоо баримтаас харагдсан ба суллагдсан иргэнийг нийгэмшүүлэхэд холбогдох яам, агентлаг, салбарын хууль эрх зүйн зохицуулалтанд тусгах, хоорондын уялдаа холбоог хангах, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх, нийгмийн хяналтыг шат дараалсан байдлаар тавих, нийгмийн байгууллага, олон нийтийн дэмжлэг туслалцаа авч ороцуулах нь нэн чухал байгааг харуулж байна.

Энэхүү илтгэлийн хүрээнд хорих байгууллагын түүхэн уламжлал, хууль, эрх зүйн бичиг баримтад дүн шинжилгээ хийх, гадаадын зарим орны туршлага дээр харьцуулсан дүгнэлт гаргах, мөн практик байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудаас кейс судалгааны аргаар ярилцлага хийж өөрийн дэвшүүлсэн таамаглалаа нотлохыг зорилоо.

1.1. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн түүхэн уламжлалаас авч үзэхэд суллагдсан иргэнд үзүүлж ирсэн тусламж, дэмжлэг тэдэнд тавих нийгмийн хяналт нь тодорхой зүйл, заалтаар баталгаажин биелэлээ олж ирсэн байна. Үүнийг хүснэгтээр харьцуулан авч үзвэл:

Хуулийн он дараалал (нэр)	Суллагдсан иргэнд тавьж байсан нийгмийн хяналт, хариуцагч байгууллага	Суллагдсан иргэнд үзүүлж ирсэн нийгэмшүүлэх үйлчилгээ
“Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль” (1931он)	Шүүх яамны дэргэдэх Засан сайжруулах газруудын хэргийг эрхлэх хэлтсийн ерөнхий удирдлага ба зааврын ёсоор хэрэг ажлаа явуулах тусгай комендатуудаас ¹ эрхлэн гүйцэтгэнэ.	1. Жинхэнэ ажлын ангийн бөгөөд хоосон ядууд мөнгө зоосоор буюу эд юмаар туслах 2. Сулагдан тавигдсан дараа уул нутагтаа буюу үргэлж оршин суух газар эргэж буцахад нь зохих зүйлээр тусгах 3. Суллагдан тавигдсаны дараа түр хэрэглэх орон сав ба хоол ундны зүйлийг хямд хөлс үнээр олгож туслах 4. Аливаа хийх ажил үйлдвэрийг эрж олгох 5. Хууль дүрэмд холбогдох хэргийн учир тусалсугай хэмээсэн зорилго болно
“БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль” (1966 он)	Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа	Шаардлагатай бол хорих ангийн фондноос мөнгөн ба эд материалын туслалцаа үзүүлж болно. АДХ-ын гүйцэтгэх захиргаа ажил олгоно.

“БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” (1981 он)	Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа	-Үнэ төлбөргүй уналгаар хангаж, тогтоосон нормоор замын хүнс буюу мөнгө олгох. -Улирлын хувцасыг үнэ төлбөргүй олгох. -Зайлшгүй шаардлагатай байвал ялаас суллагдсан хүнд орон байр олгох. -Ялаас суллагдсан тахир дутуу, өндөр настай хүнийг тэдний хүсэлтээр асрамжийн байгууллагад шилжүүлэх -Эцэг, эхгүй насанд хүрээгүй хүнийг насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс зайлшгүй тохиолдолд дотуур байртай сургууль буюу хүүхдийн бусад байгууллагад шилжүүлэх -Суллагдсан хүнийг ажилд оруулах тухай асуудал хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор аль болохоор мэргэжлийн дагуу ажлаар хангах
“Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль” (1993 он)	Заагаагүй	-Хорих ял шийтгүүлэхээс өмнө тэтгэвэр авч байсан хүнд суллагдсаны дараа урьд тогтоосон тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгоно. -Санаатай гэмт хэрэг үйлдэх үедээ гэмтэл олсон, түүнчлэн санаатайгаар гэмтэл учруулсан бусад шалтгаанаар тахир дутуугийн зэрэгт орсон хүнд суллагдсан өдрөөс эхлэн зохих тэтгэвэр олгоно.
“Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” (1995 он)		Тодорхой заагаагүй
“Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль” (1996 он)		Тодорхой заагаагүй
“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” (2002)	Гянданд ял эдэлж байсан тухайн гэмт хэргийг давтан үйлдсэн гэмт хэрэгтнийг тухайн харъяа нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.	-Шаардлагатай бол суллагдаж байгаа ялтанд тухайн улирлын хувцас олгох. Оршин суух газартаа очих уналга, хоолны зардал олгохоор заасан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд 1931-1981 оны хооронд батлан гаргасан Хорих байгууллагын тухай хуулинд суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх тэдэнд тавих хяналтын талаар тодорхой тусган, Эрүүгийн ялын зорилгыг хангахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ажиллаж ирсэн байна. Тухай үед давтан гэмт хэрэг үйлдэх ялтны тоо үзүүлэлт ч харьцангуй бага байсан мэдээ, тоо баримт байна (А.Лхагваа “Гяндан салаанаас ШШБЕГ болж өргөжсөн түүхэн замнал” 1921-2001он, 10 дахь тал УБ).

Мөн гадаадын зарим орны туршлагаас үзэхэд хорих байгууллагаас суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх, нийгмийн хяналт тавих үйлчилгээнд хууль сахиулах байгууллага, төрийн байгууллагуудын оролцоо байхаас гадна олон нийтийн дэмжлэг хяналттайгаар үйл ажиллагааг явуулж ирсэн жишээ баримт байна. Тухайлбал, Азийн орнуудаас Япон улс нь гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх ажилд нийтийн оролцоог чухалчилж буй сонгодог жишээ болсон улс гэж үзэж болно. 60 гаруй жилийн түүхтэй энэ сайн дурын албанд 48000 ажилтнууд байдаг ба эдгээр хүмүүс мэргэжлийн пробацын үйл ажиллагаатай хамтран ажиллаж гэмт хэрэгтнүүдийг нийгэмд нь хянах, амьдрахад нь туслах үүргийг гүйцэтгэдэг

төдийгүй хуулиар олгосон эрх зүйн статус, зэрэг дэвтэй байдаг. Сайн дурын пробацийн алба түүнтэй ижил төстэй бүтцүүд Азийн болон дэлхийн зарим орнуудад бий болсноор тэдгээрийн уулзалт чуулганыг мөн жил болгон зохион байгуулах болжээ. Жишээлбэл, 2014 оны 7 сард энэ асуудлаар Токио хотноо чуулган зохион байгуулагдаж гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх болон сайн дурын пробацийн ажилтан хөтөлбөрийг хөгжүүлэх үүднээс уулзалтын талаар Токиогийн тунхаглалыг мөн баталж тэрхүү тунхаглалд:

- Сайн дурын пробацийн ажилтан нь Засгийн газар болон бусад байгууллагатай хамтран ажиллах;
- Сайн дурын пробацийн ажилтныг өөрсдийнх нь хүсэл сонирхлоор энэхүү ажилд элсүүлэх;
- Холбогдох албан тушаалтан сайн дурын пробацийн ажилтныг зохих сургалт, дэмжлэг, зөвлөгөөгөөр хангах;
- Сайн дурын пробацийн ажилтны нийгмийн халамж, аюулгүй байдлыг хангах, сайн дурын үүргээ үр нөлөөтэй авч явахыг даалгах;
- Сайн дурын пробацийн ажилтныг санхүүгийн болон сэтгэл зүйн дарамтыг бууруулах арга хэмжээг авч байх, албаны үүрэгтэй нь холбогдсон нөхөн төлбөр олгох схемийг бий болгох;
- Засгийн газар энэ ажлыг идэвхжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт тавихыг даалгасан байна.²

1.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанаас суллагдах дөхсөн ялтан болон суллагдсан иргэнийг нийгэмшүүлэхэд хууль сахиулах байгууллага, төрийн үйлчилгээний байгууллагуудын үүрэг, оролцоо

Өнөөгийн байдлаар суллагдсан иргэнд хяналт, нийгэмшүүлэх үйчилгээг үзүүлж байгаа төрийн үйлчилгээний байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын оролцоог авч үзье. Энэ үйл ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага суллагдах дөхсөн ялтныг нийгэмшүүлэх нийгэмд суллагдахад бэлтгэх ажиллагааг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнуудын үүрэг, оролцоотойгоор гүйцэтгэдэг бол Прокурорын байгууллага тухайн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/107 дугаар тушаалаар “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-т тусгагдсан үндсэн үйл ажиллагааны 5.7.1-т “Ялын хугацаа дуусч, суллагдах хугацаа ойртож буй хоригдогчыг нийгмийн амьдралд гарахад бэлтгэх ажлыг дараах үндсэн хэлбэрээр зохион байгуулна” гэж тодорхой заасан байна. Үүнд:

- Нийгмийн амьдралын талаарх мэдээллээр хангах;
- Суллагдсаны дараа сэтгэлзүйн хувьд учирч болох саад бэрхшээл, эрсдлийг даван туулах чадвар эзэмшүүлэх;
- Бичиг баримтжуулах;
- Ажлын байраар хангахад зуучлах;
- Хоригдогчийн гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх;
- Төрийн холбогдох байгууллага болон төрийн бус байгууллагуудтай хамтран цаашид бие даан амьдрахад нь зуучлах³ зэрэг чиглэлийн хүрээнд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь хоригдогсдын дэглэмийн ялгааг харгалзан хорих ялын хугацаа дуусахаас 6 сарын өмнө нийгмийн амьдралд дасган хэвшүүлэх тусгайлсан төлөвлөгөөний хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлэн

² Б.Одонгэрэл “Гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэхэд нийтийн оролцоо чухал болох нь” илтгэлээс

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2010 оны А/107 дугаар “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-аас

ажиллаж байна.

Мөн нөхөн сэргээх, хоригдогч суллагдсаны дараах нийгмийн амьдралд хэвийн аж төрөх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанд зөв байр, суурьтай оролцоход чиглэгдэнэ гэсэн заалтуудын хүрээнд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанаас суллагдах дөхсөн ялтнуудад 6 сарын хугацаатай нийгэмшүүлэх ажил зохион байгуулж, суллагдан гарсан тохиолдолд тухайн иргэнд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний эрх зүйн орчин байхгүй тул Цагдаагийн байгууллага хүлээлгэн өгдөг байна.

Цагдаагийн байгууллагаас суллагдсан иргэнд захиргааны хяналт тавих талаас нь тодорхой заасан байна. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд. Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох тухай заалтын дагуу Эрүүгийн хуулийн 73-75, 86, 90, 111-113, 123, 125, 127, 239, 254 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно⁴ гэж заасан байна. Тус хуульд Захиргааны хяналтад байгаа иргэний үүргийг доорх байдлаар тодорхойлон заасан байна. Үүнд:

- нийгмийн хэв журмыг сахих;

- сард 1 удаа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх;

- цагдаагийн байгууллагаас дуудсан цагт саадгүй ирэх;

- байнга оршин суугаа газраа өөрчлөх тохиолдолд захиргааны хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж шинээр очсон газрынхаа цагдаагийн байгууллагад 3 хоногийн дотор бүртгүүлэх;

- байнга оршин суугаа газраасаа 14 хоногоос илүү хугацаагаар явах, гадаад улсад зорчих бол цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

- захиргааны хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын шаардлагыг биелүүлэх гэж заасан байна.

Мөн Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох” журамд “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох нь тухайн хүнийг засарч хүмүүжихэд нөлөө үзүүлж, дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ” заасан байна. Тэгвэл суллагдсан иргэнд нийгмийн хяналт хэн тавих, ямар хугацаатай явуулах талаар тус журмын 601 дүгээр бүлгийн 601.3.1-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс, тасгийн дарга хяналт тогтоох тогтоолыг баталж, олон нийттэй харилцах ахлах байцаагч, хүүхдийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, байцаагч захиргааны хяналтыг хэрэгжүүлнэ”⁵ гэж тусгасан байна.

Дээрх хууль, журамд заасны дагуу цагдаагийн байгууллагаас суллагдсан иргэнд тавих захиргааны хяналтыг зохион байгуулж байгаа хэдий ч тогтмол хяналт тавих боломжгүй ажлын ачаалал их, тэднийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тогтвортой явуулах, боломжгүй байгааг цагдаагийн байгууллагын албан хаагчтай хийсэн кейс судалгаанаас харж болох юм.

⁴ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль”-ийн 15 дугаар зүйлээс

⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, 601-р бүлэг, суллагдсан иргэнд тавих захиргааны хяналт

Кейс:

Намайг Б гэдэг. Цагдаагийн байгууллагад 8 жил ажиллаж байна. Манай байгууллагаас аймаг, нийслэл, сум, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс, тасгийн дарга хяналт тогтоох тогтоолыг баталж, олон нийттэй харилцах ахлах байцаагч, хүүхдийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, байцаагч захиргааны хяналтыг хэрэгжүүлдэг.

Бид нар нилээд ажлын ачаалал ихтэй гэмт хэргийн гаралт ихсэж байгаа энэ үед суллагдаад гарсан иргэнд захиргааны хяналтыг зарим тохиолдолд бүрэн тавьж чаддаггүй. Нийгэмшүүлэх үйл ажиллагаа, ажил олгох гэх мэт ажлууд дутуу явагддаг. Энэхүү үйл ажиллагааг биеэ даасан хэлтэстэй байвал зүгээр байх юм болов уу гэж боддог. Ер нь хорих байгууллагаас суллагдсан иргэн бүртгүүлэхдээ жаахан дургүй байх талтай “*би ялаа эдэлсэн хүн байнга ингэж ирмээргүй байна*” гэж хүртэл хэлж байсан. Нэг талаас үзэхэд зөв байх магадлалтай гэж бодож байна. Энэ нь тэгээд ч ар гэрийнхэн орчин тойрныхонд нь их хүнд тусдаг юм шиг санагдсан. Би нэг удаа дуудлагаар очиход суллагдсан иргэн төрсөн хүүхэдтэйгээ уулзах гээд салсан эхнэр дээрээ очсон байсан тэгтэл эхнэр нь “чам шиг шоронгийн хүнтэй хүүхдээ уулзуулахгүй” гээд загнаж байсан бас л өрөвдмөөр байсан шүү. Ер нь ШШГБ-н алба хаагчдыг хүртэл тийм ч сайнаар хүлээн авдаггүйшдээ тэгэхээр ял эдэлсэн хүнийг сайхнаар хүлээн авдаггүй байхаа.

Цагдаагийн ажилтан Б

Хорооны хөгжлийн нийгмийн ажилтны кейс

Сүүлийн үед хоригдогчийг зөвхөн хорих байгууллагад нийгэмшүүлэх бус суллагдсны нийгэмшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, тасралтгүй явуулах бодлого барьж ажиллаж байна. Үүний нэг тод жишээ нь: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2. хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох; 15.1.5. хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.⁶

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно: 13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн;⁷ гэсэн тодорхой заалтыг оруулсан нь хоригдогчийг нийгэмшүүлэх, төдийгүй давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг том алхам болж байна. Дээрх үйл ажиллагааг хороо, дүүргийн халамжын нийгмийн ажилтнууд хууль эрх зүйн хүрээнд явуулж байгаа боловч хорих байгууллагаас суллагдсан иргэнд нийгэмшүүлэх үйл ажиллагааг биечлэн хүргэх, хэрэгжүүлэх хөгжлийн нийгмийн ажилтантай уулзаж ярилцахад:

⁶ Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулиас

⁷ Монгол Улсын “Нийгмийн халамжийн тухай” хуулиас

Намайг Г гэдэг тус хороонд хөгжлийн нийгмийн ажилтнаар 4 жил ажиллаж байна. Ер хорих байгууллагаас суллагдсан иргэнд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэггүй, бидний ажил үүргийн хуваарьт нарийвчилсан байдлаар тодорхой тусгаагүй. Маш ховор байдаг ирдэггүй шүү. Судалгаанаас харахад гэр бүлийн ихэнх нь хүчирхийлэгч, хорих байгууллагад ял эдэлж байгаад ирсэн иргэн байдаг. Энгийн жишээ хэлэхэд эхнэрээ зоддог, хүүхдээ архи, тамхи хулгай гэх мэт зүйлс хийлгэдэг. Хэд хэдэн тохиолдол ч би мэднэ. Энэ бол хорих ангиас суллагдсан иргэнд тавьж байгаа нийгмийн хяналт, үйлчилгээ сул байгаагын нэг илрэл юм болов уу гэж боддог.

Цаашид суллагдсан иргэнд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг, сайн дурын байгууллага байгуулах яг мэргэшсэн нийгмийн ажилтанг бэлтгэх хэрэгтэй гэж бодож байна. Иргэн хүнтэй ажиллах, гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ажиллах гэдэг бол шал өөр гэж би бодож сэтгэхүйн хувьд хүртэл нилээд ялгаатай байна байх. Манай хорооны хэмжээнд халамжын, хөгжлийн гэсэн 2 нийгмийн ажилтантай, нийт 3000 гаруй хүн амтай хүн нэг бүрт хүрч ажиллах боломжгүй ажлын ачаалал их байдаг.

Хорооны хөгжлийн нийгмийн ажилтан Г

Дээрх кейс судалгаанаас үзэхэд хорих байгууллагаас суллагдсан иргэнд халамжын үйлчилгээг хууль эрх зүйн хүрээнд хүргэх, суллагдсан иргэнийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмд тогтвор сууршилтай амьдрах, нийгэмшүүлэх гол түлхүүр нь хууль сахиулах байгууллага, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын оролцоог хангах, хоорондын уялдаа холбоог нэгтгэх, тус тусдаа биеэ даасан үйл ажиллагаа явуулдаг тогтолцоог арилгах, нотолгоонд суурилсан үйлчилгээг үзүүлэх нь чухал ач холбогдолтой болно гэж судлаачын зүгээс үзэж байна.

Дүгнэлт

Түүхэн уламжлалаас үзэхэд хорих байгууллагаас суллагдсан иргэнд нийгмийн хяналт, нийгэмшүүлэх үйл ажиллагаа нь тодорхой шатлалтайгаар ялангуяа 1931-1918 оны хооронд маш үр дүнтэйгээр зохион байгуулж ирсэн байна.

Гадаадын улс орны туршлагаас үзэхэд хорих байгууллагад ял эдэлж байгаа ялтан болон суллагдсан иргэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээ, тэдэнд тавих хяналт зөвхөн хууль сахиулах байгууллагын чиг үүргээр хязгаарлахгүйгээр олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж явуулдаг байна.

Суллагдсан иргэнд үйлчилгээ үзүүлдэг хороо, дүүргийн хөгжлийн нийгмийн ажилтан, халамжын нийгмийн ажилтан, захиргааны хяналт тавих эрх бүхий цагдаагийн байгууллагын ажилтнуудын ажлын ачаалал их, ажил үүргийн хуваарьт нь тодорхой тусгаж өгөөгүй байна.

Сэдэвтэй холбогдуулан доорх саналыг гаргаж байна.

1. Суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх, нийгмийн хяналтыг тавьдаг хууль сахиулах байгууллага болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай холбогдох хууль, тогтоомжинд заалт оруулах.

2. Суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, нийгэмд тогтсон сөрөг хандлагыг өөрчлөх ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим шуудан, сургалт, сурталчилгааны ажлаар дамжуулан зохион байгуулах.

3. Суллагдсан иргэнд үйлчилгээ үзүүлдэг нийгмийн хяналтыг зохион байгуулдаг, олон нийтийн байгууллагыг цагдаагийн газрын харьяанд байгуулах.

4. Хороо, дүүргийн халамжын нийгмийн ажилтан, хөгжлийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд суллагдсан ялтныг нийгэмшүүлэх үйлчилгээг биечлэн явуулах заалтыг оруулан, харьяа дүүрэг, орон нутгийн хорих байгууллагын нийгмийн ажилтнуудтай холбогдох цахим сүлжээг бий болгох зэрэг саналыг гаргаж байна.